

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/88/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Орхон аймаг 2024 он	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: Ц.Одгэрэл Утас: 70357955 Цахим хаяг: odgerelts@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.08.25 № 61

танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР
СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.НЯМЦОГТ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2023 оны үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлж, батлагдсан төсвийг 7.9 хувиар хэмнэж, төсвийн гүйцэтгэл 92.1 хувьтай тайлагнасан байна.

Мөнгөн хөрөнгийн данс өмнөх оны үлдэгдлээс 136,562.4 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлдэггүй болсонтой холбоотой байна.

Аудитын гол асуудал

Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 28.4 хувиар өсөж, төсвийн хуваарийг 9 удаа өөрчлөн, 2023 оны 12 дугаар сарын 25-нд сүүлийн хуваарийг баталж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд хичээлийн байрны хүчин чадлыг 640 хүүхдээр тооцсон боловч 1015 хүүхэд суралцаж, улсын төсвөөс гүйцэтгэлээр санхүүжсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРМАНДАХ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	249,700,842.39	399,596,396.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	43,394,888.24	179,957,332.62
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	43,394,888.24	179,957,332.62
3121	Төгрөг	43,394,888.24	179,957,332.62
31211	Төрийн сангийн харилцах	43,386,494.24	179,948,938.62
31213	Арилжааны банк дахь харилцах	8,394.00	8,394.00
33	АВЛАГА	2,231,529.26	2,344,963.95
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	11,100.00	124,534.69
335	Бусад авлага	2,220,429.26	2,220,429.26
3351	Байгууллагаас авах авлага	2,220,429.26	2,220,429.26
35	БАРАА МАТЕРИАЛ	204,074,424.89	217,294,099.73
351	Түүхий эд материал	146,058,668.31	160,916,483.31
35110	Тусгай зориулалттай материал	146,058,668.31	160,705,483.31
35130	Эм боох материал	-	211,000.00
354	Хангамжийн материал	58,015,756.58	56,377,616.42
35410	Бичиг хэргийн материал	-	679,640.00
35420	Аж ахуйн материал	-	133,995.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,101,000.00	2,101,000.00
35450	Барилгын засварын материал	-	48,000.00
35470	Бусад хангамжийн материал	55,914,756.58	53,414,981.42
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,663,888,506.27	3,876,741,336.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,663,888,506.27	3,876,741,336.12
391	Газар		
392	Биет хөрөнгө	2,890,475,306.27	3,103,533,036.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,772,049,230.76	2,772,049,230.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	(193,699,286.17)	(199,487,632.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	409,587,215.10	518,565,705.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(263,426,340.15)	(303,148,463.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	138,468,176.77	315,991,376.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(87,325,306.34)	(113,092,829.73)
39209	Зам, гүүрийн байгууламж	121,319,517.75	121,319,517.75
39210	Хуримтлагдсан элэгдэл	(6,497,901.45)	(8,663,868.60)
393	Биет бус хөрөнгө	773,413,200.00	773,208,300.00
39301	Програм хангамж	10,015,550.00	10,015,550.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,802,350.00)	(4,007,250.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	767,200,000.00	767,200,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,913,589,348.66	4,276,337,732.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	517,580.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	517,580.00
413	Өглөг	-	517,580.00
4136	Бусад өглөг	-	517,580.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	517,580.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,913,589,348.66	4,275,820,152.42
51	Засгийн газрын хувь оролцоо	3,913,589,348.66	4,275,820,152.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,825,029,836.06	1,825,029,836.06
51101	Өмч: - төрийн	1,825,029,836.06	1,825,029,836.06
51102	- хувийн		
512	Хуримтлагдсан үр дүн	40,638,108.80	402,868,912.56
51210	Өмнөх үеийн үр дүн	40,638,108.80	74,504,778.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	328,364,134.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,047,921,403.80	2,047,921,403.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,913,589,348.66	4,276,337,732.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,843,630,462.07	2,647,785,584.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,891,378,262.07	241,273,684.66
120	Нийтлэг татварын бус орлого	3,891,378,262.07	241,273,684.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,983,100.00	8,411,470.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,433,100.00	3,920,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,550,000.00	4,490,670.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	3,684,432,474.02	224,024,090.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	200,962,688.05	8,838,124.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,952,252,200.00	2,406,511,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,770,756,800.00	2,297,622,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,770,756,800.00	2,297,622,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	181,495,400.00	108,889,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	181,495,400.00	108,889,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,815,005,003.67	2,319,421,450.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,815,005,003.67	2,319,421,450.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,684,297,789.94	2,187,598,855.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,316,733,669.13	1,690,606,892.12
210101	Үндсэн цалин	907,713,768.13	1,191,977,514.67
210102	Нэмэгдэл	361,200,732.00	428,770,773.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	424,400.00
210104	Урамшуулал	47,819,169.00	69,434,204.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,601,363.63	223,160,618.81
210201	Тэтгэврийн даатгал	115,026,429.82	151,863,465.31
210202	Тэтгэмжийн даатгал	13,078,383.74	17,879,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,318,047.79	14,403,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,470,743.12	3,254,653.50
210205	Эрүүл мэндийн даатгал	24,707,759.16	35,759,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,711,507.27	66,628,104.67
210301	Гэрэл, цахилгаан	10,872,106.10	13,614,050.84
210302	Түлш, халаалт	20,489,773.58	32,845,097.77
210303	Цэвэр, бохир ус	29,349,627.59	20,168,956.06
2104	Хангамж, бараа материалын зардал	20,947,419.20	6,141,484.82
210401	Бичиг хэрэг	4,464,550.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,482,869.20	-
210408	Бараа материал акталсны зардал	-	6,141,484.82
2105	Нормативт зардал	330,590.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	330,590.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,999,800.00	31,811,750.00
210604	Урсгал засвар	5,999,800.00	31,811,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,678,100.00	10,205,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,433,100.00	3,920,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,245,000.00	6,285,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,295,340.71	159,044,204.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,942,029.96	34,368,505.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,647,343.00	17,160,170.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,705,967.75	107,515,529.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,707,213.73	131,822,595.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,716,000.00	123,561,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	124,716,000.00	123,561,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,991,213.73	8,261,595.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,991,213.73	8,261,595.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4,028,625,458.40	328,364,134.12
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	197,916.80	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	197,916.80	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(197,916.80)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,028,427,541.60	328,364,134.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,959,209,509.00	2,414,923,370.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,983,100.00	8,411,470.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,983,100.00	8,411,470.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,983,100.00	8,411,470.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,433,100.00	3,920,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,550,000.00	4,490,670.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,953,226,409.00	2,406,511,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,770,756,800.00	2,297,622,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,770,756,800.00	2,297,622,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	181,495,400.00	108,889,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	181,495,400.00	108,889,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	974,209.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	974,209.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,900,589,145.76	2,215,883,325.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,900,589,145.76	2,215,883,325.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,768,907,723.03	2,084,060,730.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,430,661,398.13	1,690,606,892.12
210101	Үндсэн цалин	940,437,185.13	1,191,977,514.67
210102	Нэмэгдэл	442,430,576.00	428,770,773.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	424,400.00
210104	Урамшуулал	47,793,637.00	69,434,204.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,870,191.63	223,274,053.50
210201	Тэтгэврийн даатгал	124,917,007.25	151,976,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,241,979.73	17,879,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,225,404.61	14,403,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,680,497.44	3,254,653.50
210205	Эрүүл мэндийн даатгал	26,805,302.60	35,759,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,971,114.27	66,628,104.67
210301	Гэрэл, цахилгаан	11,507,979.10	13,614,050.84
210302	Түлш, халаалт	26,879,009.58	32,845,097.77
210303	Цэвэр, бохир ус	30,584,125.59	20,168,956.06
2104	Хангамж, бараа материалын зардал	18,134,650.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,134,650.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,999,800.00	34,000,000.00
210604	Урсгал засвар	5,999,800.00	34,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,678,100.00	10,205,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,433,100.00	3,920,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,245,000.00	6,285,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,592,469.00	59,345,880.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,803,475.00	40,825,240.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,788,994.00	18,520,640.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,681,422.73	131,822,595.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,690,209.00	123,561,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	974,209.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	124,716,000.00	123,561,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,991,213.73	8,261,595.33

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,991,213.73	8,261,595.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	58,620,363.24	199,040,044.38
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	34,162,000.00	62,477,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,162,000.00	62,477,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,162,000.00	62,477,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,162,000.00	62,477,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(34,162,000.00)	(62,477,600.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	24,458,363.24	136,562,444.38
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		43,394,888.24
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43,394,888.24	179,957,332.62

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,825,029,836.06	2,047,921,403.80	40,638,108.80	3,913,589,348.66
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,825,029,836.06	2,047,921,403.80	40,638,108.80	3,913,589,348.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			33,866,669.64	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,825,029,836.06	2,047,921,403.80	74,504,778.44	3,947,456,018.30
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			328,364,134.12	328,364,134.12
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,825,029,836.06	2,047,921,403.80	402,868,912.56	4,275,820,152.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,425,023,100.00	2,252,988,424.29	172,034,675.71	92.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,425,023,100.00	2,190,510,824.29	234,512,275.71	90.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,278,092,900.00	2,084,060,730.29	194,032,169.71	91.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,833,603,400.00	1,690,606,892.12	142,996,507.88	92.2
210101	Үндсэн цалин	1,257,621,900.00	1,191,977,514.67	65,644,385.33	94.78
210102	Нэмэгдэл	498,222,900.00	428,770,773.45	69,452,126.55	86.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт		424,400.00	-424,400.00	
210104	Урамшуулал	77,758,600.00	69,434,204.00	8,324,396.00	89.29

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	229,200,400.00	223,274,053.50	5,926,346.50	97.41
210201	Тэтгэврийн даатгал	155,856,300.00	151,976,900.00	3,879,400.00	97.51
210202	Тэтгэмжийн даатгал	18,336,000.00	17,879,600.00	456,400.00	97.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,668,800.00	14,403,600.00	265,200.00	98.19
210204	Ажилгүйдлийн даатгал	3,667,200.00	3,254,653.50	412,546.50	88.75
210205	Эрүүл мэндийн даатгал	36,672,100.00	35,759,300.00	912,800.00	97.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,889,700.00	66,628,104.67	8,261,595.33	88.97
210301	Гэрэл, цахилгаан	16,478,400.00	13,614,050.84	2,864,349.16	82.62
210302	Түлш, халаалт	34,720,300.00	32,845,097.77	1,875,202.23	94.6
210303	Цэвэр, бохир ус	23,691,000.00	20,168,956.06	3,522,043.94	85.13
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,000,000.00	34,000,000.00		100
210604	Урсгал засвар	34,000,000.00	34,000,000.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,351,500.00	10,205,800.00	2,145,700.00	82.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,920,800.00	-3,920,800.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,351,500.00	6,285,000.00	6,066,500.00	50.88
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,047,900.00	59,345,880.00	34,702,020.00	63.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,520,600.00	40,825,240.00	34,695,360.00	54.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,527,300.00	18,520,640.00	6,660.00	99.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,930,200.00	106,450,094.00	40,480,106.00	72.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	146,930,200.00	106,450,094.00	40,480,106.00	72.45
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	146,930,200.00	123,561,000.00	23,369,200.00	84.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		62,477,600.00	-62,477,600.00	
	Дотоод эх үүсвэрээр		62,477,600.00	-62,477,600.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,406,511,900.00	2,397,812,464.00	8,699,436.00	99.64
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,297,622,200.00	2,297,622,200.00		100
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,297,622,200.00	2,297,622,200.00		100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	108,889,700.00	108,889,700.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	108,889,700.00	108,889,700.00		100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		8,411,470.00	-8,411,470.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,920,800.00	-3,920,800.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,490,670.00	-4,490,670.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		43,394,888.24		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		179,957,332.62		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 34,297.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 34,297.1 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 8,838.1 мянган төгрөгийн бараа материалыг бараа материалын тодруулга тайлантай 430.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь УСНББОУС 1 болон аудитын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул санхүүгийн үр дүнгийн тайланд залруулав.
- Тайлант онд нөхөж байгуулсан Барилга, байгууламжийн өмнөх оны 33,866.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тайлант үеийн үр дүнгээр тайлагнасан нь УСНББОУС 1, 17 болон аудитын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул санхүүгийн байдлын, үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн тайланд залруулав.

Аудитаар нийт 5,225.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 2,734.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,491.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч өөртөө тушаал гарган 334.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон, сахилгын шийтгэлтэй ажилтанд 372.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, анхан шатны нотлох баримт дутуу 2,028.3 мянган төгрөгөөр эко аялал зохион байгуулсан зэрэг нийт 2,734.7 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Өмнөх оны аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 17 шийдвэрийг мэдээлээгүй, төсвийн шууд захирагчийн тушаал шийдвэргүйгээр 1,982.0 мянган төгрөгийн балансын урамшуулал, цалингийн зардлаас тэргүүний албан хаагч шалгаруулан 509.2 мянган төгрөгийн шагнал олгосон, нийт 2,491.2 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

сайдын 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил, үйлчилгээний анхан шатны баримтыг холбогдох хууль, журамд нийцүүлж, бүртгэж тайлагнах.

2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ажлын цагийн бүртгэл хөтлөлт хангалтгүй, хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Хөдөлмөрийн тухай хуулийн 84.5-д "Ажил олгогч ажилтны ажлын цагийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цагийн бүртгэл хөтлөлтийг сайжруулж, түүнд үндэслэж ажлын цагийн тооцоог гаргаж байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	2	34,297.1			2	34,297.1	2	34,297.1				
Дүн	2	34,297.1			2	34,297.1	2	34,297.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Төлбөрийн акт	Албан шаардлага	Үүнээс		
				Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	7	5,225.9	3	2,734.7	2	2,491.2	2	-				
Дүн	7	5,225.9	3	2,734.7	2	2,491.2	2	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			